

ИЛ ТОД БАЙДЛЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН
ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ ХҮСНЭГТ
/2017 он/

№	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилт	Хувь
Нэг. Үйл ажиллагааны ил тод байдал			
1.	<p>Эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл болон тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн, зохион байгуулалтын бүтцийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;</p>	<p>Байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбар, пэйж хуудсан тус бүр ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүрт нь шинэчлэн ажиллаж байна.</p> <p>Цахим хуудсанд мэдээ мэдээлэл оруулах төлөвлөгөөг гарган газрын даргаар батлуулж төлөвлөгөөний дагуу 85 мэдээ мэдээлэл, 12 тайлан мэдээ, бусад мэдээллийг холбогдох мэргэжилтнээс авч цахим хуудсанд тухай бүр байршуулсан.</p> <ul style="list-style-type: none"> - Газрын даргын тушаал - Хүний нөөц - Төсөв санхүү - Тайлан, төлөвлөгөө - Төсөл хөтөлбөр - Худалдан авалт - Өргөдөл гомдлын шийдвэрлэлт - Хууль, эрх зүй - Шилэн данс - Төрийн үйлчилгээ <p>гэх мэт цэсийг мэдээллээр тогтмол баяжуулж, цахим хуудасны хэвийн үйл ажиллагааг ханган ажиллаж байна. Мөн байгууллагаас иргэдэд үзүүлдэг төрийн үйлчилгээ-2, зөвлөмж-18 зэрэг мэдээ мэдээллийг байгууллагын цахим хуудас, facebook.com/hhaag.ub.gov.mn хуудсаар тус тус дамжуулан хүргэж байна.</p> <p>Мөн Дээд газрын тогтоол, шийдвэр, НЗД Захирамжийн мэдээллийн бааз үүсгэж тухай бүр дээд газрын тогтоол шийдвэр, захирамжийг мэдээллийг үүсгэж байна.</p>	100
2.	<p>Үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;</p>	<p>Албан хаагчдын овог нэр, холбоо барих утас, мэйл хаяг, хариуцсан ажил, гүйцэтгэх чиг үүрэг зэргийг мэдээллийг байгууллагын цахим хуудас болох hhaag.ub.gov.mn –д дэлгэрэнгүй оруулж ажилласан.</p> <p>Мөн иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг газрын даргаар шинэчлэн батлуулж, байгууллагын</p>	100

		цахим хуудас hhaag.ub.gov.mn –д байршуулсан.	
3.	Үйлчилгээ авахад шаардагдах бичиг баримтын жагсаалтыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	Манай байгууллагаас иргэд болон аж ахуйн нэгжид үзүүлдэг төрийн 2 үйлчилгээний мэдээлэл, шаардлагатай материалын жагсаалтыг цахим хуудаснаа байршуулан тухай бүр шинэчлэн ажиллаж байна.	100
4.	Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	Байгууллагын цахим хуудсанд дээд газраас манай байгууллагатай холбогдуулан гаргасан хууль, тогтоол, захирамж, дүрэм журмыг тухай бүрт нь шинэчлэн байршуулж байна.	100
5.	Шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг болон захиргааны хэм хэмжээний актын шийдвэрийн төслийг цахим хуудсандаа 30-аас доошгүй хоног ойлгомжтой байдлаар байрлуулж, холбогдох төрийн ба төрийн бус байгууллага, мэргэжлийн шинжээч, эрдэмтэн, иргэдийн саналыг авах, үндэслэлтэй гэж үзвэл уг саналыг төсөлд тусгах;	2017 онд шинээр боловсруулагдаж байгаа бодлогын баримт бичиг болон холбогдох бичгийн шийдвэрүүд гараагүй болно.	0
6.	Үзүүлж байгаа үйлчилгээний арга, хэлбэрийг боловсронгуй болгох зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх;	Манай байгууллагаас иргэд аж ахуйн нэгжид үзүүлдэг төрийн 2 үйлчилгээг smartcity.mn /төрийн үйлчилгээ цэс/ цахим хуудсаар дамжуулан хүлээн авч шийдвэрлэх байсан боловч тус цэс ажиллахгүй байгаа тул edoc.ub.gov.mn албан бичгийн програмаар хүлээн авч хуулийн хугацаанд нь шийдвэрлэлээ. Үүнд: Тамхины импортын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр авах болон хугацаа сунгуулах хүсэлт гаргасан 6, согтууруулах ундааны болон тамхины үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацаа сунгуулах хүсэлт гаргасан 8, сүүн бүтээгдэхүүнээр нэрсэн шимийн архи үйлдвэрлэх зөвшөөрөл хүссэн 1 аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд Нийслэлийн Засаг даргын 2016 оны А/811 дүгээр захирамжаар батлагдсан Ажлын хэсэг хяналт тавьж, холбогдох дүгнэлтийг гарган ажилласан байна.	100
7.	Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу төрийн байгууллагын гүйцэтгэх тодорхой чиг	2017 онд төрийн байгууллагын гүйцэтгэх тодорхой чиг үүргийг төрийн бус байгууллага гүйцэтгэж байгаа ажил байхгүй байна.	0

	үүргийг төрийн бус байгууллага гүйцэтгэж байгаа тохиолдолд тухайн төрийн бус байгууллагын нэр, хаяг, цахим хуудас, эрхэлж байгаа үйл ажиллагааны чиглэлийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлэх;		
8.	Тухайн байгууллага тодорхой төрлийн аж ахуйн үйл ажиллагаа эсхүл бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгодог бол тухайн зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацааг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	2017 онд манай байгууллага нь НЗД-н А/387 тоот захирамжаар “Гум ХХК”-д Шимийн архины үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон. Тус компаны тусгай зөвшөөрөл олгосон зөвшөөрөл, эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацааны мэдээллийг байгууллагын цахим хуудсандаа оруулан ажилласан.	100
9.	Салбарын хэмжээнд улсын төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, явц, байдлын талаарх мэдээллийг цахим хуудсандаа байрлуулан тухай бүр шинэчлэх;	2017 онд манай салбарын хэмжээнд улсын төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа ямар нэгэн төсөл, хөтөлбөр байхгүй болно.	0
Хэсгийн дундаж хувь:			55%